



2017 оны 10 дугаар сарын 20  
№39/996/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Хөтөлбөр батлах тухай**

**Орон нутгийн хөгжлийн  
нэгдсэн сан болон Орон нутгийн  
хөгжлийн сангаас олгох орлогын  
шилжүүлгийг тооцох аргачлал  
батлах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

523.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 223	1965
524.	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай	Дугаар 230	1976

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 223

Улаанбаатар  
хот

#### Хөтөлбөр батлах тухай

Тариалангийн тухай хуулийн 21.1, 22.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.40 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



4. “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг орон нутгийн хөрс, уур амьсгалын онцлогт тохируулан улсын хэмжээнд хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, үр дүнг жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнаж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**П.СЭРГЭЛЭН**

Засгийн газрын 2017 оны 223 дугаар  
тогтоолын хавсралт

### “ЖИМС, ЖИМСГЭНЭ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Жимс, жимсгэнэ нь үр, жимсэндээ олон төрлийн амин дэм, биологийн идэвхт бодис агуулдаг тул хүн амын эрүүл мэнд, хүнс, гоо сайхны нэн чухал тарималд тооцогддог. Жимс, жимсгэнийн үйлдвэрлэл нь олон жилийн уйгагүй хөдөлмөр, хөрөнгө санхүүжилт, туршлага, ур чадвар шаарддаг бөгөөд төр засгаас тууштай, урт хугацааны тогтвортой дэмжлэг үзүүлж байж үр дүнд хүрдэг онцлогтой. Манай орны хувьд өргөн уудам нутаг дэвсгэртэй, байгаль, эрс тэс уур амьсгалын бүсүүдэд байгалийн 60 гаруй төрлийн жимс, жимсгэнэ ургадаг бөгөөд эрдэмтэн, судлаачид, олон төрлийн жимс, жимсгэнийг тариалж нутагшуулах, үржүүлэх агротехнологийг боловсруулан шинэ сорт гаргах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологийг хөгжүүлсээр байна.

Монгол Улсын Засгийн газраас 2010-2016 онд “Чацаргана” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр жимс, жимсгэнийн тариалалт, үйлдвэрлэл 4-6 дахин нэмэгдэн жимст цэцэрлэгийн хэмжээ 6.07 мянган га талбайд хүрч, жилд 2560 орчим тонн жимс хураан авч байна. Гэвч энэ нь хүн амын физиологийн хэрэгцээт жимсний 1.5 хүрэхгүй

хувийг хангаж, жил бүр 18-22 мянган тонн жимс, жимсгэнийг импортоор авч байна. Нийт тариалсан жимс, жимсгэнийн 92 хувийг чацаргана, 8 хувийг бусад жимс, жимсгэнэ эзэлж байна. Мөн нэг талаас хүн амын хүнсний хэрэглээнд жимс, жимсгэнийн эрэлт хэрэгцээ өсч байгаа бөгөөд нөгөө талаар чацаргана болон байгалийн жимсний бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сонирхох хандлага нэмэгдэж байна.

Энэхүү хөтөлбөрийг таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадварыг сайжруулан дотоод, гадаад зах зээлд өсөн нэмэгдэж байгаа жимс, жимсгэнийн эрэлт хэрэгцээг тогтвортой хангах, ажлын байр, экспортыг нэмэгдүүлэх, өрхийн болон аж ахуйн нэгжийн орлогыг өсгөх, хүн амын хүнсэн дэх жимс, жимсгэнийн хангамжийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.40-д “Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганын үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.” гэж заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

#### Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

##### 2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

2.1.1. бүтээгдэхүүний өртгийн сүлжээний аль ч шат дамжлагад олон улсын стандарт, чанар, эрүүл ахуйн шаардлагыг баримтлах;

2.1.2. экспортын баримжаатай, импорт орлох экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих;

2.1.3. байгальд ээлтэй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан техник, технологийн дэвшил, инноваци, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх;

2.1.4. төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, салбарын мэргэжлийн холбоодын оролцоог хангах.



## Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Хөтөлбөрийн зорилго нь жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн чацарганын тариалалтыг 10 мянган га, бусад төрлийн жимс, жимсгэнийн тариалалтыг 2 мянган га талбайд хүргэж, хүн амыг экологийн цэвэр, амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

## Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1. жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх;

4.1.2. жимс, жимсгэнийн таримлын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх;

4.1.3. жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах;

4.1.4. салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх.

## Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. “Жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх” зорилтын хүрээнд:

5.1.1. жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инноваци

нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;

5.1.2. чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг экспортлоход учирч байгаа саад тотгорыг арилгах, дотоод зах зээлийг импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах;

5.1.3. эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улстай байгуулсан хэлэлцээр болон бусад улстай байгуулах чөлөөт худалдаа, олон талт хэлэлцээрт тэдгээр орны зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх гол бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг нэмж оруулах асуудлыг судлан шийдвэрлэх;

5.1.4. шинээр тариалж, ургуулан үр жимсээ тогтвортой өгч эхэлсэн мод, бутны тоогоор таримлын төрлөөс хамааруулан нэг удаагийн урамшуулал олгох;

5.1.5. жимс, жимсгэнийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, усалтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног төхөөрөмж суурилуулах, тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд, аж ахуйн нэгжид санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;

5.1.6. жимс, жимсгэнийн сортыг хянан баталгаажуулж, хяналт тавин мөрдүүлэх;

5.1.7. жимс, жимсгэнэ тариалж ажлын байр олгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр, зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах;

5.1.8. жимс, жимсгэнийн өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүс нутгийн нөөц, байгаль цаг уурын онцлог, дэд бүтэц, ложистик, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх;

5.1.9. жимс, жимсгэнийн кластерийн гол оролцогч болон хамтрагч, тариалагч хооронд үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуваарилах, ложистик, тээвэр, банк, санхүүгийн байгууллага, даатгал, боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоог хангах;



5.1.10. бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, худалдааны дэвшилтэт арга, хамтын ажиллагааг хөгжүүлж, тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ (Global өртгийн сүлжээ г.м)-г үүсгэх, түүнийг орон нутгийн нөөцөд түшиглэсэн дэд кластер болгон хөгжүүлэх;

5.1.11. инноваци, шинэ технологийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн (хөлдөөсөн, хатаасан, нөөшилсөн, нунтаг, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зэрэг) болон шинэ сорт гаргах, усалгаажуулах, хураах технологийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

5.1.12. жимс, жимсгэнэ тариалдаг иргэн, аж ахуйн нэгжид өртгийн сүлжээний санхүүжилтийн талаар таниулах, сурталчлах, өөрийн орны онцлогт нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх;

5.1.13. жимс, жимсгэнийн тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих;

5.1.14. кластерийн бүрэлдэхүүн хэсэг бүрт чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, GAP, GLOBAL GAP, ISO, HACCP зэрэг олон улсын стандартуудыг нэвтрүүлэх, хураасан жимсний хадгалах, тээвэрлэх (хөргөлттэй агуулах, машин зэрэг), сав, баглаа боодлын нэгдсэн стандартыг батлан мөрдүүлэх;

5.1.15. Монгол чацаргана бүтээгдэхүүний стандартыг тогтоох, түүнийг олон улсад баталгаажуулах, чацарганыг органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, брэнд болгон хөгжүүлэх;

5.1.16. хүнсний аюулгүй байдалд нийцсэн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн батлах, мөрдүүлэх.

5.2. “Жимс, жимсгэнийн таримлын сорт шалгаруулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, ган, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, нутагшсан сортын суулгацын хангамжийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд:

5.2.1. бүсийн эрдэм шинжилгээний байгууллагууд, томоохон аж ахуйн нэгжүүдийг түшиглэн жимс, жимсгэнийн төрөл, зүйлийн

сорт нутагшуулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац үйлдвэрлэлийн ажлыг эрчимтэй явуулах;

5.2.2. алим, чавга, интоор, чацаргана, үхрийн нүд, нэрс, гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, хад зэрэг жимс, жимсгэнийн сортын суулгацын ил талбайн болон хүлэмжийн эх цэцэрлэг, үржүүлгийн загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч, жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хувийн хөнгөлөлттэй үнээр болон урт хугацаатай зээлээр олгох;

5.2.3. жимс, жимсгэнийн суулгац үржүүлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ургац, чанарыг дээшлүүлэх, тарьц, суулгацыг шинжлэх ухааны үндэслэлтэй үржүүлэх, дэвшилтэт технологийг боловсруулах, агроэкологийн бүсүүдэд нэвтрүүлэх;

5.2.4. байгалийн жимс, жимсгэнийн нэр төрөл, тархалт, нөөц, генетикийн судалгааг үе шаттай явуулах, тэдгээрийн генетик нөөц, селекцийн эх материалд тулгуурлан өөрийн орны байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон сорт, дээжүүдийг турших.

5.3. “Жимс, жимсгэнийн тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах” зорилтын хүрээнд:

5.3.1. орчин үеийн технологид суурилсан хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлж, дулаан нөхцөл шаарддаг усан үзэм, тоор, лийр, нимбэг, гүзээлзгэнэ, анар, улаан чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулах, тариалалтыг нэмэгдүүлэх;

5.3.2. байгалийн жимс, жимсгэнийг тарималжуулан үйлдвэрлэлийн нөөц бий болгож, үйлдвэрлэлд нийлүүлэх;

5.3.3. жимс, жимсгэнийн тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг цогцоор нь боловсруулах;

5.3.4. чацарганыг хатаах, хөлдөөх, хуурайшуулах, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх, тосыг нь чанарын





өндөр түвшинд боловсруулах, чацарганын жимс, навч, мөчир, холтсыг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах туршилт явуулах, дэвшилтэт технологи нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

5.3.5. Монгол чацарганын (таримал болон байгалийн) биохими, генетик, бүтээгдэхүүний шинж чанар, хүнсний хангамж, эрүүл мэнд, гоо сайхан зэрэгт үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан судалгааг хөгжүүлж, онцлог шинж чанарыг нь тогтоон олон улсын түвшинд баталгаажуулах;

5.3.6. жимс, жимсгэнийн үйлдвэрлэлд хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд түүхий эд, бүтээгдэхүүнд хүнсний пестицидийн үлдэгдэл, хувиргасан амьд организмыг хянах лабораторийн болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;

5.3.7. жимс, жимсгэнийн талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агротехнологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх;

5.3.8. өөрийн орны онцлогт тохирсон жимс, жимсгэнийн талбай, хүлэмжид усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хураалтыг механикжуулах;

5.3.9. салбарын хүний нөөцийн хэрэгцээг судалж, хэтийн бодлоготой уялдсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

5.3.10. чацаргана, жимс, жимсгэнийн чиглэлээр ажиллаж байгаа судлаач, мэргэжилтэн, аж ахуй, үйлдвэрлэл эрхлэгч, сонирхогчдыг дэмжин дотоод, гадаадын мэргэжлийн сургалт, туршлага судлах арга хэмжээнд өргөн хамруулах, харилцан туршлага солилцох, тэдгээрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

5.3.11. байгаль цаг уурын нөхцөл ойролцоо хөрш орны жимс, жимсгэнийн судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж болон салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч олон улсын байгууллагатай холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

5.3.12. залгаж ургуулах аргаар үрт болон яст жимсний үржүүлэг хийх, талбайд болон хүлэмжид жимс, жимсгэнэ тариалах, мод, бутны таналт, тайралт, хэлбэржүүлэлтийг зохистой хийх арга технологийг



зэмшүүлэх чиглэлээр сургалтад хамруулж шинэ технологитой танилцах, туршлага судлах, тэдгээрийг нэвтрүүлэх;

5.3.14. мэргэжлийн ахисан түвшний хөтөлбөрүүдийг боловсруулж, эрчимжсэн, дунд, урт хугацааны сургалтыг мэргэжлийн байгууллагыг түшиглэн явуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх;

5.3.15. жимс, жимсгэнийн аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдэд зориулсан мэргэжлийн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх багийг сонгон шалгаруулах, үйлдвэрлэгч, тариаланчдыг танхимын, талбайн, ажлын байран дахь сургалтад хамруулж, чадавхжуулах.

5.4. “Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх” зорилтын хүрээнд:

5.4.1. хүнамддотоодын жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх дадал бий болгох, хэрэглээг нэмэгдүүлэх, ач тусыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;

5.4.2. жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах байгууллагууд болон төрийн өмчийн аж ахуйн нэгж) дэмжих нөхцөлийг бүрдүүлэх;

5.4.3. жимс, жимсгэнэ тариалагчид үйлдвэрлэсэн жимсээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд гаргахад нь дэмжлэг үзүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ үүсгэх боломжийг бүрдүүлэх;

5.4.4. жимс, жимсгэнийн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн судалгаа хийх, түүнд тулгуурлан экспортын бүтээгдэхүүний маркетинг хөгжүүлэх;

5.4.5. жимс, жимсгэнэ, чацарганын болон үрийн холбоо зэрэг олон улсын байгууллагын туршлагаас суралцах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, мэргэжилтэн, судлаачдыг чадавхжуулах, бүтээгдэхүүнээ сурталчлах;

5.4.6. эх орны хөрсөнд тарьж ургуулсан экологийн цэвэр жимс, жимсгэнэ, чацарганын үнэ цэнийг дээшлүүлж, үйлдвэрлэгчид болон



борлуулагч, хэрэглэгчдийг холбох биржийн арилжаа, үнэ хаялцуулах худалдаа зэрэг шинэлэг дэвшилтэт маркетинг нэвтрүүлэх, төрөлжсөн худалдааны төв байгуулж ажиллуулах.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1. “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

6.2. Жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, бизнесийн таатай орчинг сайжруулан жилд чацарганын 2 саяас доошгүй суулгац, бусад төрлийн жимс, жимсгэнийн 1 сая суулгац бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, чацарганын тариалалтын хэмжээг 10 мянган га, бусад төрлийн жимс, жимсгэнийг 2 мянган га хүртэл нэмэгдүүлнэ.

№	Тариалах жимсний төрөл	Хэмжээ
1	Алим	450 га
2	Чавга	300 га
3	Интоор	200 га
4	Үхэр нүд	820 га
5	Нэрс	150 га
6	Бусад жимс (хүлэмж)	80 га
7	Чацаргана	10000 га

6.3. Экологийн цэвэр жимс, жимсгэнэ, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ өсч, жимс, жимсгэнийн дотоодын хэрэгцээний 10 хувийг хангадаг болно.

6.4. Жимс, жимсгэнийн эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийн хөгжлийг гүнзгийрүүлж, улмаар жимс, жимсгэнээ дотоодын хэрэгцээнээс гадна экспортод тогтвортой гаргадаг болно.

6.5. Жимс, жимсгэнийн тариалалтын талбайн хөрсний үржил шим сайжирч, тариалалт нэмэгдэнэ.

6.6. Байгалийн жимс, жимсгэнийг тарималжуулсан талбайн хэмжээ нэмэгдэж, үйлдвэрлэлийн нөөц, хэрэгцээ хангагдана.

6.7. Таримал жимс, жимсгэнийн нэр төрөл олширч, тэдгээрийг хэрэглэх соёл дээшилснээр хүн ам аюулгүй, экологийн цэвэр жимс,



жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэж хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө.

6.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр жимсний аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр дагнан ажиллах 15 мянгаас доошгүй ажлын байр бий болж, жимс, жимсгэнийн аж ахуйн салбар нь газар тариалангийн бие даасан дэд салбар болон хөгжинө.

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018 он)	Зорилтот түвшин (2022 он)
1	Чацаргана, жимс, жимсгэнэ тариалсан талбай	га	6070	12000
2	Хураан авсан ургац	тонн	2560	20000
3	Бэлтгэсэн суулгац	сая ширхэг	2.4	3.0
4	Дотоодын үйлдвэрлэлийн жимс, жимсгэнийн хангамж	хувь	1.5	10
5	Шинэ ажлын байрны тоо	хүн	4000	11000
6	Экспортолсон бүтээгдэхүүний мөнгөн дүн	сая ам. доллар	0.2	5.0
7	Чацарганын кластер/өртгийн сүлжээ		-	Өртгийн сүлжээ үүссэн байна

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөлийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

7.2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох яам, агентлагийн удирдах албан тушаалтан, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцох бөгөөд зөвлөлийн гишүүдийг Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө.

7.3. Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл ажиллаж, дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл орж ажиллана.



7.4. Сум, дүүргийн иргэдийн Хурал, Засаг дарга нь жимс, жимсгэнэ тариалахад тохиромжтой (ус, хөрс, дэд бүтэц зэргийг харгалзан) газруудад иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

#### Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 8.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 8.1.2. гадаадын зээл, тусламж;
- 8.1.3. дотоод, гадаадын хөрөнгө оруулалт;
- 8.1.4. хувийн хөрөнгө оруулалт;
- 8.1.5. бусад эх үүсвэр.

8.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

#### Ес. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

9.1. Төрийн захиргааны төв байгууллага үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу зохион байгуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар  
хот

**Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон  
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын  
шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 59.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан аргачлалыг баримтлан Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг тооцож, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт болон мөн тогтоолын 3, 4 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ**

**САНГИЙН САЙД**

**Б.ЧОЙЖИЛСҮРЭН**

Засгийн газрын 2017 оны 230 дугаар  
тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН  
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС ОЛГОХ  
ШИЛЖҮҮЛЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн орлого, эх үүсвэрийг төлөвлөх, тэдгээр сангаас доод шатны төсөвт олгох орлогын шилжүүлгийг тооцоход энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Энэ аргачлалд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.28-д заасныг;

1.2.2. “орон нутгийн хөгжлийн сан” гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн



ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг;

1.2.3. “орлогын шилжүүлэг” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.22-т заасныг;

1.2.4. “орон нутгийн хөгжлийн индекс” гэж Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн индекс тооцох аргачлал”-аар тооцож гаргасан итгэлцүүрийг.

1.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тооцно.

1.4. Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг аймаг, нийслэлийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгж тооцно.

1.5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь төв төрийн санд, орон нутгийн хөгжлийн сан нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байна.

Хоёр. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр

2.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь Төсвийн тухай хуулийн 59.1-д заасан эх үүсвэр, тэдгээрийн хувь хэмжээнээс бүрдэнэ:

2.1.1. импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлого;

2.1.2. ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого;

2.1.3. орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;



2.1.4. газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого.

2.2. Орон нутгийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 60.2-т заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.2.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

2.2.2. Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хөрөнгө;

2.2.3. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

2.2.4. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

2.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөв, тодотгосон төсөвт тусгаж төлөвлөнө.

2.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд тооцож олгох орлогын шилжүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан сар, улирлын хуваарийн дагуу Төсвийн тухай хуулийн 56.3-т заасан нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд тухайн сарын төсвийн мэдээ гарсны дараа аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.

2.5. Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг ажлын 3 хоногийн дотор сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хуваарилна.

Гурав. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан,  
Орон нутгийн хөгжлийн сангаас орон нутгийн төсөвт  
олгох шилжүүлэг тооцох итгэлцүүр, түүнд ашиглах  
мэдээлэл, мэдээллийн эх сурвалж

3.1. Тухайн төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг тооцох дор дурдсан итгэлцүүрийг холбогдох байгууллагаас хамгийн сүүлд гаргасан албан ёсны мэдээлэлд үндэслэнэ. Үүнд:





3.1.1. орон нутгийн хөгжлийн индексийг Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн индекс тооцох аргачлал”-д заасны дагуу үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас нийтэд зарласан үзүүлэлтүүдээс дараах 5 бүлгийн үзүүлэлтийг ашиглана. Үүнд:

- дэд бүтцийн хангамж;
- хүрээлэн байгаа байгаль орчин;
- нийгэм, эдийн засгийн байдал;
- хөгжлийн нөөц, давуу тал;
- хөдөө аж ахуй.

3.1.2. Үндэсний статистикийн хорооноос нийтэд зарласан Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, аймгийн төвөөс нийслэл хүртэлх хот хоорондын замын урт;

3.1.3. орон нутгийн татварын идэвх санаачилгын индексийг тооцохдоо холбогдох мэдээллийг дараах эх үүсвэрээс ашиглана:

3.1.3.1. орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг тооцохдоо санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нийтэд мэдээлсэн тухайн төсвийн жилийн өмнөх жилийн төлөвлөгөө болон гүйцэтгэл, тухайн төсвийн жилийн эхний хагас жилийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тоон мэдээг;

3.1.3.2. татвар төлөгчийн татварт хамрагдсан байдлын үзүүлэлтийг тооцохдоо татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас нийтэд мэдээлсэн тухайн төсвийн жилийн өмнөх жилийн татвар төлөгчийн тоон мэдээ, тухайн төсвийн жилийн эхний хагас жилийн татвар төлөгчийн тоон мэдээг;

3.1.3.3. татварын өр барагдуулалтын үзүүлэлтийг тооцоход татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас нийтэд мэдээлсэн тухайн төсвийн жилийн өмнөх жилийн урьд оны өр, тайлангийн болон хяналт шалгалтын барагдуулалтын тоон мэдээ, тухайн төсвийн жилийн эхний хагас жилийн урьд оны өр, тайлангийн болон хяналт шалгалтын барагдуулалтын тоон мэдээг;

3.1.3.4. орон нутгийн татварын хувь хэмжээг хуульд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлаас тогтоосон үзүүлэлтийг.

3.2. Энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг дор дурдсан байдлаар хувийн жинд харгалзуулан орлогын шилжүүлгийн хуваарилалтыг тооцно. Үүнд:

3.2.1. орон нутгийн хөгжлийн индекс-харгалзах хувийн жин 25 хувь;

3.2.2. хүн амын тоо-харгалзах хувийн жин 25 хувь;

3.2.3. хүн амын нягтрал, алслалтын хэмжээ-харгалзах хувийн жин 25 хувь;

3.2.4. орон нутгийн татварын идэвх санаачилга-харгалзах хувийн жин 25 хувь.

Индексэд харгалзах хуваарилалтыг томъёогоор илэрхийлбэл:

$$N=0.25$$

$N$  – индексэд харгалзах хувь

$$M \times N = M_d = M_p = M_L = M_t$$

$M$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн нийт дүн; (аргачлалын 2.1 -т заасан эх үүсвэрүүдийн нийлбэр)

$M_d$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн индексээс хамаарч харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн;

$M_p$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хүн амын тооноос хамаарч харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн;

$M_L$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хүн амын нягтрал, алслалтын, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн;

$M_t$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн татварын идэвх санаачилгын индексээс хамаарч харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн.

3.3. Энэ аргачлалын 2.1.3-т заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллага талаас хүлээн авагч талыг болон хуваарилалтын аргачлалыг тусгайлан заасан тохиолдолд аргачлалыг дараах байдлаар ашиглана.

3.3.1. энэ аргачлалын 2.1.3-т заасан уг эх үүсвэрийг ОНХНС-гаар дамжуулан аймаг, нийслэлд олгож байгаа тохиолдолд ОНХНС-гаас аймаг, нийслэлийн ОНХС-нд орлогын шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн нэр заагдсан аймаг, нийслэлийн түвшинд хуваарилагдах хөрөнгийг тооцно.



3.3.2. энэ аргачлалын 2.1.3-т заасан эх үүсвэрийг аймаг, нийслэлийн ОНХС-гаар дамжуулан сум, дүүрэгт олгож байгаа тохиолдолд аймаг, нийслэлийн хөгжлийн сангаас сум, дүүргийн хөгжлийн санд орлогын шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн нэр заагдсан сум, дүүргийн түвшинд хуваарилагдах хөрөнгийг тооцно.

3.3.3. энэ аргачлалын 2.1.3-т заасан уг эх үүсвэрийг ОНХС-гаар дамжуулан нэр заасан сум, дүүрэгт олгож байгаа тохиолдолд 3.3.1-д заасан аргачлалаар тооцсон аймаг, нийслэлд хуваарилагдах дүнгээс 3.3.2-т заасан аргачлалыг баримтлан сум, дүүрэгт хуваарилах дүнг тооцоолно.

3.3.4. ОНХС-гийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд суурилсан урамшууллыг тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй. Өөрөөр хэлбэл уг аргачлалыг ашиглахгүй.

**Дөрөв. Орон нутгийн хөгжлийн индекс ашиглан  
орлогын шилжүүлгийн дүнг тооцох**

4.1. Орон нутгийн хөгжлийн индексээс хамааруулан олгох орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо аймгуудын хөгжлийн индексийг Улаанбаатар хотын түвшинд, бусад аймгуудын хөгжлийг өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх зорилгоор хөгжлийн индекс багатай орон нутгийн засаг захиргааны нэгжид илүү хөрөнгө хуваарилагддаг байх зарчим баримтлах ба хөгжлийн индексээс хамаарах хуваарилалтад аймгуудыг хамруулна.

4.2. Орон нутгийн хөгжлийн индексээс хамааран аймагт хуваарилах шилжүүлгийг энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн уг индекст харгалзах энэ аргачлалын 3.2-т заасан хувиар тооцно.

4.3. Энэ аргачлалын 3.1.1-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн индексийг аймаг бүрээр тооцож, түүнээс аймгуудын дунджийг арифметикийн дунджаар тооцон гаргана.

4.4. Аймгуудын дундаж хөгжлийн индексийг тухайн аймгийн хөгжлийн индекстэй харьцуулан дүйцүүлэх индексийг тооцно.

4.5. Аймаг бүрийн дүйцүүлэх индексийг хүн амын тоогоор үржүүлж бүх аймгуудын нийлбэр индекс (хүн амын тоогоор үржүүлсэн)-д харьцуулан хүн амын тоогоор жигнэсэн индексийг орон нутгийн хөгжлийн индексээс хамааруулан хуваарилах эх үүсвэрийн дүнгээр үржүүлж аймаг

тус бүрийн хөгжлийн индексээс хамаарсан орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн дүнг тодорхойлно.

Орон нутгийн хөгжлийн индексээс хамаарах дүнг тодорхойлох аргачлалыг томъёогоор илэрхийлбэл:

$$D_i = \frac{f_i}{\sum_{i=1}^n f_i} \times M_d$$

$i$  – тухайн аймаг, нийслэлийн харгалзах индекс;

$n$  – аймгийн нийт тоо;

$D_i$  – орон нутгийн хөгжлийн индексээс хамаарч тухайн аймагт олгох шилжүүлгийн дүн;

$M_d$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн индексээс хамаарч, харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн (аргачлалын 4.2);

$f_i$  – тухайн аймгийн улсын дундажтай дүйцүүлэх индексийг тухайн аймгийн хүн амын тоогоор үржүүлсэн индекс.

$$f_i = \frac{a}{d_i} \times p_i$$

$a$  – аймгийн хөгжлийн индексийн арифметик дундаж (улсын дундаж индекс)

$d_i$  – тухайн аймгийн хөгжлийн индекс

$p_i$  – тухайн аймгийн хүн амын тоо

Тав. Хүн амын тооноос хамаарах шилжүүлгийн дүн тооцох

5.1. Хүн амын тооноос хамааруулан олгох орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо хүн ам ихтэй орон нутгийн засаг захиргааны нэгжид хөрөнгө илүү хуваарилах зарчим баримтална.

5.2. Хүн амын тооноос хамааран аймаг, нийслэлд хуваарилах дүнг энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн уг индексэд харгалзах энэ аргачлалын 3.2-т заасан хувиар тооцно.

5.3. Энэ аргачлалын 3.1.2-т заасны дагуу хүн амын тоог аймаг, нийслэл бүрээр тооцно.

5.4. Тухайн аймаг, нийслэлд оршин сууж байгаа хүн амын тоог хүн амын нийт тоонд харьцуулсан харьцааг хүн амын тооноос хамааран хуваарилах эх үүсвэрийн дүнгээр үржүүлж тухайн аймаг, нийслэлд олгох дүнг тодорхойлно.



Хүн амын тооноос хамаарах дүнг тодорхойлох аргачлалыг томъёогоор илэрхийлбэл:

$$P_i = \frac{p_i}{\sum_{i=1}^n p_i} \times M_p$$

$i$  – тухайн аймаг, нийслэлийн харгалзах индекс;

$n$  – аймаг, нийслэлийн нийт тоо;

$P_i$  – хүн амын тооноос хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн дүнг;

$M_p$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хүн амын тооноос хамаарч, харгалзах хувиар тооцсон дүнг (аргачлалын 5.2);

$p_i$  – тухайн аймаг, нийслэлийн хүн амын тоо.

Зургаа. Хүн амын нягтрал, алслалтын хэмжээнээс  
хамаарах шилжүүлгийн дүнг тооцох

6.1. Хүн амын нягтрал, алслалтын хэмжээнээс хамааран аймаг, нийслэлд хуваарилах дүнг энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн уг индексэд харгалзах энэ аргачлалын 3.2-т заасан хувиар тооцно.

6.2. Энэ аргачлалын 6.1-д заасан дүнг дор дурдсан үзүүлэлт тус бүрт тэнцүү хэмжээгээр хуваарилна:

6.2.1. хүн амын нягтрал 1/2;

6.2.2. алслалт 1/2.

6.3. Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээг хүн амын тоонд нь харьцуулан хүн амын нягтралын хэмжээг тооцох ба тус бүрийг 1-д харьцуулах замаар харгалзах урвуу индексийг гаргана.

6.4. Аймаг, нийслэлийн хүн амын нягтралын урвуу индексийг хүн амын тоогоор үржүүлж бүх аймгуудын нийлбэр индекс (хүн амын тоогоор үржүүлсэн)-д харьцуулсан индексийг 6.2.1-т заасан харьцаагаар тооцсон хүн амын нягтралаас хамааруулан хуваарилах эх үүсвэрийн дүнгээр үржүүлж аймаг, нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг тодорхойлно.

6.5. Энэ аргачлалын 3.1.2-т заасан мэдээлэлд үндэслэн алслалтын индексийг тооцохдоо тухайн аймгийн алслалтыг хамгийн их алслагдсан аймгийн алслалтын хэмжээнд харьцуулж алслалтын индексийг тооцно.

6.6. Алслалтын индексийг хүн амын тоогоор үржүүлж бүх аймгуудын нийлбэр индекс (хүн амын тоогоор үржүүлсэн)-д харьцуулсан индексийг 6.2.2-т заасан харьцаагаар тооцсон алслалтаас хамааруулан хуваарилах эх үүсвэрийн дүнгээр үржүүлж аймаг, нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг тодорхойлно.

Хүн амын нягтрал, алслалтын хэмжээнээс хамаарах дүнг тодорхойлох аргачлалыг томъёогоор илэрхийлбэл:

$$L_i = C_i + V_i$$

$L_i$  – хүн амын нягтрал, алслалтын хэмжээнээс хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн дүнг;

$C_i$  – хүн амын нягтралын урвуу индексээс хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн дүнг;

$$C_i = \frac{(1/c_i) \times p_i}{\sum_{i=1}^n (1/c_i) \times p_i} \times m_c$$

$c_i$  – хүн амын нягтралын индекс (хүн амын тоог нутаг дэвсгэрийн хэмжээнд харьцуулсан);

$m_c$  – хүн амын нягтралаас хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох дүнг (6.2.1);

$p_i$  – тухайн аймаг, нийслэлийн хүн амын тоо;

$V_i$  – алслалтын индексээс хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн дүнг;

$$V_i = \frac{v_i \times p_i}{\sum_{i=1}^n v_i \times p_i} \times m_v$$

$v_i$  – тухайн аймаг, нийслэлийн алслалтын индекс;

$m_v$  – алслалтаас хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох дүнг (6.2.2);

$$M_l = m_c + m_v$$

Долоо. Орон нутгийн татварын идэвх санаачилгаас хамаарах шилжүүлгийн дүнг тооцох

7.1. Орон нутгийн татварын идэвх санаачилгаас хамааруулан олгох орлогын шилжүүлгийн дүнг тооцоход орлогын төлөвлөгөөний биелэлт, татвар төлөгчийн татварт хамрагдсан байдал, татварын өр төлбөрийн барагдуулалт, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон татварын хувь хэмжээ нь хуульд заасан доод хувь хэмжээнээс нэмэгдсэн буюу татварын идэвх санаачилга өндөртэй орон нутгийн засаг захиргааны нэгжид хөрөнгө илүү хуваарилагддаг байх зарчим баримтална.



7.2. Орон нутгийн татварын идэвх санаачилгаас хамааран аймаг, нийслэлд хуваарилах дүнг энэ аргачлалын 2.1-д заасан эх үүсвэрээс бүрдэх орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийн уг индексэд харгалзах энэ аргачлалын 3.2-т заасан хувиар тооцно.

7.3. Энэ аргачлалын 7.2-т заасан дүнг тооцохдоо энэ аргачлалын 7.1-д заасан үндсэн 4 үзүүлэлтийн арифметик дундаж индексийг хүн амын тоогоор үржүүлж бүх аймгуудын нийлбэр индекс (хүн амын тоогоор үржүүлсэн)-д харьцуулсан индексийг ашиглана.

7.4. Орон нутгийн татварын төлөвлөгөөний биелэлтийн үзүүлэлтийг тооцохдоо энэ аргачлалын 3.1.3.1-д заасан тоон мэдээг үндэслэж орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийн дунджаар тооцно.

7.5. Татвар төлөгчийн татварт хамрагдсан байдлын үзүүлэлтийг энэ аргачлалын 3.1.3.2-т заасан тоон мэдээг үндэслэж орон нутгийн орлогын нэр төрлөөр татварт хамруулалтын хувийн дунджаар тооцно.

7.6. Татварын өр барагдуулалтын үзүүлэлтийг энэ аргачлалын 3.1.3.3-т заасан тоон мэдээг үндэслэж орон нутгийн татварын өрийн барагдуулалтын хувийн дунджаар тооцно.

7.7. Энэ аргачлалын 3.1.3.4-т заасан үзүүлэлтийг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон орон нутгийн татварын хувь хэмжээг, хуульд заасан татварын доод хувь хэмжээтэй харьцуулсан хувийн дунджаар тооцно.

Орон нутгийн татварын идэвх санаачилгаас хамаарах дүнг тодорхойлох аргачлалыг томъёогоор илэрхийлбэл:

$$T_i = M_t \times t_i$$

$T_i$  – татварын идэвх санаачилгаас хамаарч тухайн аймаг, нийслэлд олгох шилжүүлгийн дүн;

$M_t$  – орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас татварын идэвх санаачилгаас хамаарч, харгалзах хувиар тооцсон дүн ( аргачлалын 3.2.4);

$t_i$  – тухайн аймаг, нийслэлийн татварын идэвх санаачилгын индекс;

$$t_i = (r_i + b_i + h_i + e_i) / 4$$

$r_i$  – тухайн аймаг, нийслэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт;

$b_i$  – тухайн аймаг, нийслэлийн татвар төлөгчийн татварт хамрагдсан үзүүлэлт;

$h_i$  – тухайн аймаг, нийслэлийн татварын өр барагдуулалтын үзүүлэлт;

$e_i$  – тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн татварын хувь хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоосон үзүүлэлт;

$z_t$  – тухайн аймаг, нийслэлийн хүн амын тоогоор жигнэсэн татварын идэвх санаачилгын индекс;

$$z_t = \frac{t \times p_i}{\sum_{i=1}^n t_i \times p_i}$$

$p_i$  – тухайн аймаг, нийслэлийн хүн амын тоо;

Найм. Аймаг, нийслэлийн хөгжлийн сангаас сум,  
дүүргийн хөгжлийн санд олгох орлогын  
шилжүүлгийг тооцох зарчим

8.1. Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг сум, дүүргийн хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу дараах байдлаар хуваарилна:

8.1.1. аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс Төсвийн тухай хуулийн 59.2.1-т заасны дагуу суурь зардалд ногдох хэсэг (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжихээр батлагдсан суурь зардал)-ийг нь тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилна.

8.1.2. аймаг, нийслэл нь энэ аргачлалын 3.3-т заасны дагуу тооцсон эх үүсвэрийг тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.

8.2. Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т зааснаас доошгүй хувь хэмжээгээр сум, дүүргийн ОНХС-нд хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1 болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилагдсан сум, дүүргийг мөн багтаан тооцно.





8.3. Аймаг, нийслэл нь энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно:

8.3.1. хүн амын тооноос хамаарах-40 хувь;

8.3.2. алслалтаас хамаарах-30 хувь;

8.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах-30 хувь.

Индексэд харгалзах хуваарилалтыг томъёогоор илэрхийлбэл:

$$n_p = 0.40; n_l = 0.30; n_t = 0.30$$

$n$  – индексэд харгалзах хувь

$$m_p = m \times n_p; \quad m_l = m \times n_l; \quad m_t = m \times n_t$$

$m$  – орон нутгийн хөгжлийн сангаас итгэлцүүрээр тооцож олгох орлогын нийт дүн;

$m_p$  – орон нутгийн хөгжлийн сангаас хүн амын тооноос хамаарч, харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн;

$m_l$  – орон нутгийн хөгжлийн сангаас алслалтаас хамаарч, харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн;

$m_t$  – орон нутгийн хөгжлийн сангаас нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарч, харгалзах хувиар хуваарилахаар тооцсон дүн.

Сум, дүүргийн хувьд алслалтаас хамаарах дүнг тодорхойлох аргачлалыг томъёогоор илэрхийлбэл:

$$v_i = \frac{v_i \times p_i}{\sum_{i=1}^n v_i \times p_i} \times m_i$$

$v_i$  – тухайн сум, дүүргийн алслалтын индекс

$p_i$  – тухайн сум, дүүргийн хүн амын тоо

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

**Индекс:** 200003